

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/08/31

Дуусах хугацаа: 2026/09/30

Ажил эхлэх хугацаа: 2026/10

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Хотхоны дулаан, цахилгаан, ус хангамж, бохирын системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах
- Дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмж, насос, салхивч болон холбогдох системүүдийн ашиглалт, бэлэн байдалд хяналт тавих
- Барилга байгууламжийн ашиглалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах
- Засвар үйлчилгээ, урьдчилан сэргийлэх болон аваар, саатлын үед авах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдүүлэх

Тавигдах шаардлага:

- Барилгын инженер болон холбогдох чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх
- Мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
- Цахилгаан, дулаан, дэд бүтцийн ашиглалт, засвар үйлчилгээний мэдлэгтэй байх
- Засвар үйлчилгээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах ур чадвартай байх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) мэдлэгтэй байх (сургалтад хамрагдсан сертификаттай бол давуу тал болно)
- Багаар болон бие даан ажиллах, асуудал шийдвэрлэх чадвартай, хариуцлагатай, шуурхай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг эзэмшсэн байх

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар - CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.